



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/226

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
өвлүүлж эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Наванпэрэнлэй овогтой Пүрэвдоржийн газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөж авах тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан өв залгамжлагч иргэн Пүрэв овогтой Мөнгөнтуулд Хэрлэн сумын 4 дүгээр баг, Тариаланчдын гудамж В-04 тоот хаягт байрлах үйлчилгээний зориулалттай 3520 м² газрыг өвлүүлж эзэмшүүлсүгэй.

2. Иргэн П.Мөнгөнтуулын эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөн авсан иргэнтэй гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн П.Мөнгөнтуулд даалгасугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 35 дугаар захирамжийн хавсралтын 8 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА